



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

ШУДАРГА ИРГЭДИЙН НЭГДСЭН
ЭВСЭЛ НАМЫН СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛД

2020.07.31 № 000 2020/07-37
танай -ны № -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын Сэлэнгэ аймгийн орон нутгийн зөвлөлтийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сэлэнгэ аймгийн болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын Сэлэнгэ аймгийн орон нутгийн зөвлөлтийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгур болгосон.

Дүгнэлт


Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын Сэлэнгэ аймгийн орон нутгийн зөвлөлийн Сэлэнгэ аймгийн болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын Сэлэнгэ аймгийн орон нутгийн зөвлөлийн мөрийн хөтөлбөр / .../ хуудас /-ийг хавсаргав.

Хувийг: Сэлэнгэ аймгийн болон сумдын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



**Сэлэнгэ аймаг болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны
сонгуульд оролцох Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын мөрийн
хөтөлбөр**



Ерөнхий зүйл: УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд ШИНЭ нам, Бүгд Найрамдах нам, Үнэн ба Зөв нам, Монгол Ундэсний Ардчилсан намуудын “ШИНЭ ЭВСЭЛ”-ээс дэвшүүлсэн “ШИНЭ ЭРГЭЛТИЙН БОДЛОГО-21” мөрийн хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхийг үндсэн зорилт болгон ажиллана.

Хамтдаа хөгжих 10 зорилт:

1. Орон нутагт намчирхал, талцахыг таслан зогсоно.
2. Орон нутгийн төсвийн зарцуулалтад хатуу хяналт тогтооно.
3. Аливаа асуудал, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхдээ тухайн орон нутгийн иргэдэд мэдээллийг урьдчилан танилцуулж, нээлттэй, өргөн хэлэлцүүлэг хийсний дараа шийдвэр гаргадаг жишгийг тогтооно.
4. Орон нутгийн ИТХ, төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг мэдээллийн бүхий л хэрэгсэл, олон нийтийн сүлжээг ашиглан тогтмол мэдээлж, байнгын, бодит өгөөжтэй эргэх холбоог бий болгоно.
5. Тухайн орон нутгийн иргэдийн хамтарч, хоршиж, ажиллах аливаа санал, санаачилгыг дэмжиж ажиллана.
6. Иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай, хүнд сурталгүй, хялбар, энгийн ойлгомжтой болгох талаар төрийн захиргааны байгууллагууд болоод тухайн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүдтэй нягт хамtran ажиллана.
7. Нийтийн өмч, зам талбайн ашиглалт, хамгаалалт, эрүүл ахуйн нөхцөл байдал, орчны аюулгүй байдлын хяналт, шалгалтад тухайн орон нутгийн иргэдийн сайн дурын оролцоог эрс нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
8. Төв суурин газрын гудамж, орчны тоосжилтыг бууруулах талаар иргэдийн оролцоонд суурилсан санаачилга гарган ажиллана.
9. Хүүхдийн тоглох суралцах орчны эрүүл аюулгүй байдлыг хангах зорилтыг тэргүүлэх бодлого болгоно.
10. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөөс үзүүлдэг халамжаас гадна тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамtran сайн дурын үндсэн дээр нэгдэж халамж туслалцаа үзүүлдэг тогтолцоог хэвшүүлэх ажиллагааг санаачлан эхлүүлнэ.

ШУДАРГА ИРГЭДИЙН НЭГДСЭН ЭВСЭЛ НАМ

